



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/29

Ховд

Усан замын тээврийн талаар авах  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.2, Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аливаа осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа нутаг дэвсгэрийн гол, мөрөн, нуур цөөрөмд усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн улирлыг дуусгах, усан замын тээврийн үйл ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дараа оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсоосугай.

2. Усан замын зорчигч, ачаа тээвэрлэхгүй байх талаар холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч, олон нийтэд суртчлан, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын газар /Л.Батбаяр/, Онцгой байдлын газар /Б.Алтанбадралт/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0154  
Zah A/29 Kh